Golomt Capital®

# ДЭЛХИЙН

## ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ



2025.05.12

# Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- Ням гарагийн орой АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Хятадтай өндөр түвшний хэлэлцээний үр дүнд худалдааны гэрээ байгуулагдсаныг зарласны дараа АНУ-ын голлох индексүүдийн фьючерс ханш огцом өсөв.

- Мөн 1-р улирлын санхүүгийн тайлангууд ерөнхийдөө эерэг гарсан нь зах зээлийн өсөлтийг дэмжсэн

- Одоогоор АНУ Хятадын импортод 145%-ийн тариф ногдуулсан байгаа бөгөөд энэ тарифийг 50%-ийн түвшинд бууруулах тухай яригдаж буй. Ерөнхийлөгч Трамп өмнө нь "80% орчим нь оновчтой тоо" хэмээн мэдэгдэж байв.

- Ерөнхийлөгч Трамп Ням гарагт хэлэхдээ, эмийн жорын болон эмийн үнийг 30% - 80%-иар бууруулах гүйцэтгэх тушаалд Даваа гарагийн өглөө 9:00 цагт гарын үсэг зурахаа мэдэгдэв

### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

| | |
|---|---|
| Deutsche Bank | 7,000 |
| Société Générale | 6,750 |
| BMO Capital Markets | 6,700 |
| Bank of America | 6,666 |
| Barclays | 6,600 |
| RBC Capital Markets | 6,600 |
| Wells Fargo | 6,500 |
| Citigroup | 6,500 |
| Goldman Sachs | 6,500 |
| Morgan Stanley | 6,500 |
| JPMorgan Chase | 6,500 |
| UBS | 6,400 |
| **Дундаж** | **6,678** |



# АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.05.05-05.11

## ХЭЛЭЛЦЭЭР МЭДЭЭГЭЭР АНУ ЗАХ ЗЭЭЛ ОГЦОМ ӨСЛӨӨ

АНУ-ын фьючерсийн ханш Хятадтай хийсэн худалдааны хэлэлцээрийн мэдээгээр огцом өсөв. Ням гарагийн орой АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Хятадтай өндөр түвшний хэлэлцээний үр дүнд худалдааны гэрээ байгуулагдсаныг зарласны дараа АНУ-ын голлох индексүүдийн фьючерс ханш огцом өсөв. Гэсэн хэдий ч хэлэлцээрийн нарийн мэдээллийг одоогоор дэлгээгүй байна.

Индексүүдийн хөдөлгөөн (ET цагаар 19:07):

- Dow Jones фьючерс: +1.0% → 41,736.0 оноо
- S&P 500 фьючерс: +1.2% → 5,745.0 оноо
- Nasdaq фьючерс: +1.5% → 30,438.75 оноо

Өнгөрсөн долоо хоногийн Уолл Стритийн эерэг уур амьсгал үргэлжилж байгаа нь Хятад-АНУ-ын хэлэлцээр ахицтай явагдсан гэсэн хүлээлт, эрсдэл дагуулсан хөрөнгийн ангилалд хөрөнгө оруулагчид идэвхтэй оролцож буйтай холбоотой. Мөн 1-р улирлын санхүүгийн тайлангууд ерөнхийдөө эерэг гарсан нь зах зээлийн өсөлтийг дэмжсэн бөгөөд Home Depot (HD), Palo Alto Networks (PANW), Lowe’s (LOW), Target, Snowflake (SNOW) зэрэг томоохон компанийн тайлангууд энэ долоо хоногт нийтлэгдэх хүлээлттэй байна.

## АНУ-ХЯТАДЫН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР ШВЕЙЦАРЬТ АМЖИЛТТАЙ БОЛЛОО

АНУ-ын Сангийн сайд Скотт Бессент болон Худалдааны төлөөлөгч Жэймисон Грир нар Ням гарагийн үдээс хойш мэдэгдэл хийж, Хятадтай худалдааны гэрээ байгуулснаа зарласан ч дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй байна.

“Хятадын түншүүдтэй байгуулсан энэхүү хэлэлцээр нь худалдааны алдагдлыг бууруулах чиглэлд ахиц гаргана гэдэгт бид итгэлтэй байна” хэмээн Грир Цагаан ордны цахим хуудсанд нийтэлсэн мэдэгдэлдээ дурджээ.

Тэрбээр, "Хэлэлцээр маш хурдан амжилтад хүрсэн нь зөрөлдөөний хэмжээ анх бодсоноос бага байсныг харуулж байна" гэж онцолсон бол Сангийн сайд Бессент “Хэлэлцээр маш чухал ахиц гаргасан” хэмээн тэмдэглээд, Ерөнхийлөгч Трамптай холбогдсон бөгөөд Даваа гарагийн өглөө бүрэн мэдээлэл хийнэ гэж мэдэгджээ.

Хятадын төрийн хэвлэл мэдээллээр, хоёр тал Даваа гарагт хамтарсан мэдэгдэл хийх бөгөөд Худалдааны дэд сайд Ли Чэнганг “Мэдэгдэл аль ч үед гарсан, энэ нь дэлхий дахинд том, сайн мэдээ байх болно” гэжээ.

Одоогоор АНУ Хятадын импортод 145%-ийн тариф ногдуулсан байгаа бөгөөд энэ тарифийг 50%-ийн түвшинд бууруулах тухай яригдаж буй. Ерөнхийлөгч Трамп өмнө нь "80% орчим нь оновчтой тоо" хэмээн мэдэгдэж байв.

## ТРАМП ЭМИЙН ҮНИЙГ БУУРУУЛАХ ТУШААЛ ГАРГАНА

Ерөнхийлөгч Трамп Ням гарагт хэлэхдээ, эмийн жорын болон эмийн үнийг 30% - 80%-иар бууруулах гүйцэтгэх тушаалд Даваа гарагийн өглөө 9:00 цагт гарын үсэг зурахаа мэдэгдэв. Энэ бол манай улсын түүхэн дэх хамгийн чухал тушаалуудын нэг байх болно хэмээн Трамп онцолсон бөгөөд АНУ-ын иргэдэд шударга үнэтэй эм хүргэхийн тулд дэлхийн бусад орны эмийн үнэ нэмэгдэнэ гэж мэдэгджээ.

# Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.05.05 – 05.11

## БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ ӨСӨЛТТЭЙ БАЙНА.

**Өсөлтийн шалтгаан: Худалдааны хэлэлцээ ба мөнгөний бодлогын хариу арга хэмжээ**

Хятадын хөрөнгийн зах зээл долоо хоногийн эхэнд өсөлттэй эхэлсэн нь АНУ болон Хятадын албаны хүмүүс Швейцарьт амралтын өдрүүдэд худалдааны хэлэлцээр хийхээр явна гэсэн мэдээтэй холбоотой. Үүнээс гадна БНХАУ-ын Төв банкнаас гэнэтийн бодлогын хөнгөлөлтийн алхам авсан нь зах зээлийн уур амьсгалыг илүү өөдрөг болгожээ. Лхагва гарагт, БНХАУ-ын Ардын банк (PBOC) 7 хоногийн репо хүүг 1.5%-иас 1.4% болгон бууруулж, мөн банкуудын нөөцийн шаардлагын нормыг 0.5 нэгжээр бууруулсан нь эдийн засагт 1 их наяд орчим юань урт хугацааны хөрвөх чадварыг нийлүүлэх бодлогын алхам болж байна. Мөн төв банкнаас банкууд руу чиглэсэн зээл болон дахин санхүүжүүлэлтийн хүүг бууруулах зэрэг бусад зөөлрүүлэх арга хэмжээг зарлажээ. Эдгээр алхамууд нь АНУ-ын Трампын засгийн Хятадын бараанд ногдуулах тарифыг 145% болгон нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор Бээжин эдийн засгаа хамгаалах хариу арга хэмжээ авч буйг харуулж байна.

**Хятадын экспортын тайлан: АНУ руу буурсан ч бусад бүс нутгуудад өсөв.**

Хятадын Статистикийн газар баасан гарагт мэдээлснээр, 2024 оны 4-р сард экспорт 8.1% өссөн нь хүлээлтээс өндөр байсан ч өмнөх сард (12%) үзүүлсэн өсөлтөөс доогуур байв. АНУ руу чиглэсэн экспорт нэг жилийн өмнөхөөс 21%-иар унасан нь тарифын өсөлттэй холбоотой. Харин Энэтхэг, Зүүн өмнөд Азийн орнууд болон Европын Холбоо руу чиглэсэн экспорт эрс өссөн нь Хятадын компаниуд АНУ-ын зах зээлээс хамааралаа бууруулахыг оролдож байгааг харуулж байна. Худалдааны хэлэлцээ Швейцарьт болсон. Хятадын дэд Ерөнхий сайд Хэ Лифэн болон АНУ-ын Сангийн сайд Скотт Бессент нар худалдааны хэлэлцээг ахлан энэ Бямба гарагт Женев хотод хоёр өдрийн турш уулзалт хийлээ. Одоогийн нөхцөлөөр хэрэгжиж буй АНУ-ын тарифууд Хятадын экспорт болон бизнесийн итгэлд хүчтэй доргилт өгөх магадлалтай. Гэсэн хэдий ч хэлэлцээрийн нарийн мэдээллийг одоогоор дэлгээгүй байна. Хятадын Засгийн газар эдийн засгийг дэмжих санхүүгийн чадавхитай бөгөөд татварын болон төсвийн урамшууллыг шат дараатайгаар хэрэгжүүлэх замаар энэ нөлөөг зөөллөх боломжтой бас байгаа юм.



## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

